

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГСА-2025/022/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Говьсүмбэр аймаг  
2025 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа  
Утас: 70543179, Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)  
Аудитын менежер: Г.Наранбаяр  
Цахим хаяг: [naranbayarg@audit.gov.mn](mailto:naranbayarg@audit.gov.mn)  
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Платиниум прогресс аудит” ХХК  
Захирал: Ж.Баяртуул  
Утас: 99066015, Цахим хаяг: [platinumprogressaudit@gmail.com](mailto:platinumprogressaudit@gmail.com)  
Аудитор: Г.Гантуяа  
Утас: 99060147, Цахим хаяг: [platinumprogressaudit@gmail.com](mailto:platinumprogressaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2025.02.17 № 04.  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ШИВЭЭГОВЬ СУМЫН 3 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ТӨСВИЙН  
ЗАХИРАГЧ Б.ДАВААДОЛГОР  
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



**Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>127,139,339.18</u></b>	<b><u>250,944,522.51</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	73,792,114.46	163,529,499.75
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	73,792,114.46	163,529,499.75
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	73,792,114.46	163,529,499.75
31211	Төрийн сангийн харилцах	65,553,660.46	151,691,045.75
21218	Ахмадын сангийн харилцах	8,238,454.00	11,838,454.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	12,004.04
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	12,004.04
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	53,347,224.72	87,403,018.72
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	53,347,224.72	87,403,018.72
35410	Бичиг хэргийн материал	551,000.00	551,000.00
35420	Аж ахуйн материал	43,976,108.00	70,937,008.00
35450	Барилгын засварын материал	50,000.00	50,000.00
35460	Хүнсний материал	2,037,236.00	9,132,130.00
35470	Бусад хангамжийн материал	6,732,880.72	6,732,880.72
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>337,476,388.88</u></b>	<b><u>507,001,648.99</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>337,476,388.88</b>	<b>507,001,648.99</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>322,006,388.88</b>	<b>491,531,648.99</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	302,567,567.66	302,567,567.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(30,559,750.53)	(35,644,743.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	61,112,800.00	74,916,458.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,582,697.67)	(20,890,295.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,849,640.55	19,954,218.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,288,799.14)	(3,490,665.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,614,342.50	163,045,733.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,423,148.69)	(8,926,623.23)
39217	Ном	3,716,434.20	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>15,470,000.00</b>	<b>15,470,000.00</b>
39301	Програм хангамж	1,122,000.00	1,122,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,122,000.00)	(1,122,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,470,000.00	15,470,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>464,615,728.06</u></b>	<b><u>757,946,171.50</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>464,615,728.06</u></b>	<b><u>757,946,171.50</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>464,615,728.06</b>	<b>757,946,171.50</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	331,693,656.51	331,693,656.51
51101	Өмч: - төрийн	331,693,656.51	331,693,656.51
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(57,183,198.69)</b>	<b>236,147,244.75</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(121,290,388.50)	(60,899,632.89)
51220	Тайлант үеийн үр дүн	64,107,189.81	297,046,877.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	190,105,270.24	190,105,270.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>464,615,728.06</u></b>	<b><u>757,946,171.50</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>915,326,400.00</b>	<b>1,533,091,899.86</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>19,775,000.00</b>	<b>214,479,699.86</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	19,775,000.00	214,479,699.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,775,000.00	214,479,699.86
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,216,900.00	11,680,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	10,036,500.00	188,966,949.86
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,521,600.00	13,832,750.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>895,551,400.00</b>	<b>1,318,612,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	842,473,400.00	1,236,210,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	842,473,400.00	1,236,210,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	53,078,000.00	82,402,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,078,000.00	82,402,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>851,219,210.19</b>	<b>1,236,045,022.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>851,219,210.19</b>	<b>1,236,045,022.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	840,366,650.23	1,229,725,710.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	566,382,851.17	883,472,420.91
210101	Үндсэн цалин	374,760,262.30	542,494,247.35
210102	Нэмэгдэл	178,161,002.59	310,246,853.56
210104	Урамшуулал	13,461,586.28	30,731,320.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	72,295,398.27	109,911,199.76
210201	Тэтгэврийн даатгал	47,812,798.27	75,706,106.91
210202	Тэтгэмжийн даатгал	6,120,900.00	8,986,097.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,896,700.00	4,628,051.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,223,800.00	4,219,800.36
210205	Эрүүл мэндийн даатгал	12,241,200.00	16,371,143.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,584,810.04	65,483,058.68
210301	Гэрэл, цахилгаан	8,606,763.27	10,124,331.91
210302	Түлш, халаалт	25,479,766.77	43,661,736.77
210303	Цэвэр, бохир ус	8,498,280.00	11,696,990.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,078,056.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,521,600.00	-
210408	Бараа материал акталсны зардал	4,556,456.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	105,262,084.00	111,824,046.00
210502	Хоол, хүнс	105,262,084.00	111,824,046.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,099,130.00	10,599,630.00
210604	Урсгал засвар	5,099,130.00	10,599,630.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	935,000.00	3,805,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	935,000.00	3,805,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	41,729,320.75	44,629,755.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,085,670.00	25,105,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,308,150.00	3,798,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,335,500.75	15,725,255.55
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,852,559.96	6,319,311.32
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,458,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,458,500.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	5,394,059.96	6,319,311.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,394,059.96	6,319,311.32

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	64,107,189.81	297,046,877.64
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	64,107,189.81	297,046,877.64

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>903,768,300.00</b>	<b>1,330,292,200.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,216,900.00</b>	<b>11,680,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	8,216,900.00	11,680,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	8,216,900.00	11,680,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,216,900.00	11,680,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>895,551,400.00</b>	<b>1,318,612,200.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	842,473,400.00	1,236,210,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	842,473,400.00	1,236,210,200.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	53,078,000.00	82,402,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,078,000.00	82,402,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>835,580,754.44</b>	<b>1,240,554,814.71</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>835,580,754.44</b>	<b>1,240,554,814.71</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>824,728,194.48</b>	<b>1,234,235,503.39</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	566,382,851.17	883,484,424.95
210101	Үндсэн цалин	374,760,262.30	542,494,247.35
210102	Нэмэгдэл	178,161,002.59	310,258,857.60
210104	Урамшуулал	13,461,586.28	30,731,320.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	72,295,398.27	109,911,199.76
210201	Тэтгэврийн даатгал	47,812,798.27	75,706,106.91
210202	Тэтгэмжийн даатгал	6,120,900.00	8,986,097.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,896,700.00	4,628,051.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,223,800.00	4,219,800.36
210205	Эрүүл мэндийн даатгал	12,241,200.00	16,371,143.18
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,584,810.04	65,483,058.68
210301	Гэрэл, цахилгаан	8,606,763.27	10,124,331.91
210302	Түлш, халаалт	25,479,766.77	43,661,736.77
210303	Цэвэр, бохир ус	8,498,280.00	11,696,990.00
2105	<b>Нормативт зардал</b>	100,835,480.00	118,918,940.00
210502	Хоол, хүнс	100,835,480.00	118,918,940.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,099,130.00	10,599,630.00
210604	Урсгал засвар	5,099,130.00	10,599,630.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,629,150.00	3,805,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,629,150.00	3,805,600.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	35,901,375.00	42,032,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,012,175.00	31,012,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,889,200.00	11,019,800.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,852,559.96</b>	<b>6,319,311.32</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,458,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,458,500.00	-
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	5,394,059.96	6,319,311.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,394,059.96	6,319,311.32
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>68,187,545.56</b>	<b>89,737,385.29</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,360,000.00</b>	-
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,360,000.00</b>	-

/төгрөгөөр/

<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,360,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,360,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,360,000.00)</u></b>	<b>≡</b>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	66,827,545.56	89,737,385.29
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	6,964,568.90	73,792,114.46
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	73,792,114.46	163,529,499.75

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	331,693,656.51	190,105,270.24	(121,290,388.50)	400,508,538.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>331,693,656.51</b>	<b>190,105,270.24</b>	<b>(121,290,388.50)</b>	<b>400,508,538.25</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	64,107,189.81	64,107,189.81
<b>8</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>331,693,656.51</b>	<b>190,105,270.24</b>	<b>(57,183,198.69)</b>	<b>464,615,728.06</b>
<b>9</b>	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>331,693,656.51</b>	<b>190,105,270.24</b>	<b>(57,183,198.69)</b>	<b>464,615,728.06</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,716,434.20)	(3,716,434.20)
<b>11</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>331,693,656.51</b>	<b>190,105,270.24</b>	<b>(60,899,632.89)</b>	<b>460,899,293.86</b>
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	297,046,877.64	297,046,877.64

17	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,693,656.51	190,105,270.24	236,147,244.75	757,946,171.50
----	--	----------------	----------------	----------------	----------------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,380,275,200.00	1,226,155,503.39
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,380,275,200.00	1,226,155,503.39
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,380,275,200.00	1,226,155,503.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,015,999,200.00	883,484,424.95
210101	Үндсэн цалин	667,414,600.00	542,494,247.35
210102	Нэмэгдэл	342,451,800.00	310,258,857.60
210104	Урамшуулал	6,132,800.00	30,731,320.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	117,778,100.00	109,911,199.76
210201	Тэтгэврийн даатгал	80,091,500.00	75,706,106.91
210202	Тэтгэмжийн даатгал	9,419,900.00	8,986,097.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,711,000.00	4,628,051.84
210204	Ажилгүйдлийн даатгал	4,711,000.00	4,219,800.36
210205	Эрүүл мэндийн даатгал	18,844,700.00	16,371,143.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	71,802,000.00	65,483,058.68
210301	Гэрэл, цахилгаан	12,100,000.00	10,124,331.91
210302	Түлш, халаалт	46,062,000.00	43,661,736.77
210303	Цэвэр, бохир ус	13,640,000.00	11,696,990.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	121,845,600.00	118,918,940.00
210502	Хоол, хүнс	121,845,600.00	118,918,940.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,600,000.00	10,599,630.00
210604	Урсгал засвар	10,600,000.00	10,599,630.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,805,600.00	3,805,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,805,600.00	3,805,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	38,444,700.00	33,952,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,424,900.00	22,932,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,019,800.00	11,019,800.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,380,275,200.00	1,312,292,888.68
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,236,210,200.00	1,236,210,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,236,210,200.00	1,236,210,200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	82,402,000.00	76,082,688.68
122005	Орон нутгийн төсвөөс	82,402,000.00	76,082,688.68
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	61,663,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	61,663,000.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	65,553,660.46
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	151,691,045.75

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 966.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3 зөвлөмж өгсөн. Завсрын аудитаар 966.1 мянган төгрөгийн алдаанд 2 зөвлөмж өгсөн, 1 зөвлөмжийг жилийн эцэст өгсөн.

### Завсрын аудитын талаар

2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 966.1 мянган төгрөгийн 2 алдаа илрүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах тухай зөвлөмж хүргүүлсэн болно. Үүнд:

- Нэг ажилтны ээлжийн амралтын 57.6 мянган төгрөгийн цалинг дутуу тооцож олгосон,
- Ажил гүйлгээний хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 908.5 мянган төгрөгийн өглөг үүсгэж ажилласан

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 3.1 Төлбөрийн акт байхгүй

### 3.2 Албан шаардлага байхгүй

### 3.3 Зөвлөмж

1. Илүү цагийн дундаж цалин хөлс тооцоололтой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт Цэцэрлэгийн 31 багш, ажиллагсдын илүү цагийн нэмэгдэл хөлсийг алдаатай тооцоолж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/192 дугаар "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 2.1.2-т "нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо ажилтанд тодорхой хугацаанд олгосон цалин хөлсний нийлбэрийг тухайн хугацаанд ажилласан нийт өдрийн тоонд хувааж" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Багш, ажиллагсдын илүү цагийн нэмэгдэл хөлсийг хууль журам нийцүүлэн үнэн зөв тооцож олгох зөвлөмж өгөв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



